

SouthGobi Resources Ltd. (TSX: SGQ, HK: 1878)

Зорилтот үнэ **1.04** Канад доллар, **BUY** үнэлгээ

Бид Торонтогийн Хөрөнгийн Бирж (TSX) дээр бүртгэлтэй SouthGobi Resources Ltd. ("SGQ" эсвэл "Компани") компанийг судалсны дагуу уг хувьцааны зорилтот үнийг 1.04 канад доллараар дүгнэж BUY үнэлгээ санал болгож байна.

Компанийн үйл ажиллагаа

Саусгоби Ресурс Лимитед нь 2007 онд Торонтогийн Хөрөнгийн бирж (TSX: SGQ), 2010 онд Хонконгийн хөрөнгийн биржид (HKEX: 1878) бүртгэгдсэн. Компани нь Өмнөговь аймагт коксжих болон эрчим хүчний нүүрс олборлох, боловсруулах болон хайгуулын ажил хийж БНХАУ-ын хэрэглэгчдэд нийлүүлдэг. Тус компани нь Овоот толгой уурхай, Сүмбэрийн орд, болон Заг сүүжийн ордыг эзэмшдэг.




Компанийн бүтэц

Монгол Улсад нүүр олборлож буй Саусгоби сэндс ХХК нь Канадад төвтэй Саусгоби Ресурс Лимитед (SGQ) компанийн Монгол дахь салбар бөгөөд 100 хувь эзэмшилд нь багтдаг. Харин Саутгоби Ресурс Лимитед нь Канадын Айвенхоу Майнзын охин компани юм. Саусгоби Ресурс компанийн эцэг компани болох Айвенхоу Майнз 2006 оны 10 сард Лондон болон Мельбурнд төвтэй Рио Тинто компанитай стратегийн түншлэл байгуулж, дэлхийд томоохонд тооцогдох Оюу Толгойн төсөлд хамтран оролцож байв.

SGQ (Canada: TSX)

10/15/21

Үнэлгээ	BUY
Хаалтын үнэ (Канад доллар)	0.60
1 жилийн дээд/доод ханш	0.01 - 1.39
Хувьцааны тоо ширхэг (сая)	273,624
Зах зээлийн үнэлгээ (сая C\$)	178.07
Зорилтот ханш (Канад доллар)	1.04



Эх сурвалж: Yahoo Finance, MSE

Үндсэн харьцаанууд (06/30/21)

SGQ

P/E Ratio	3.44
Debt/Equity	4.0
Current Ratio	0.6
EPS	0.02

Үндсэн санхүүгийн үзүүлэлтүүд (сая ам.доллар)


	06.30.2021	12.31.2020
Нийт орлого	33.3	85.9
ББӨ	(22.9)	(58.6)
Цэвэр ашиг	5.8	(20.1)

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц (10/08/21)

■ Институцууд ■ Стратегийн ■ Бусад



Томоохон хувьцаа эзэмшигчид (10/08/21)



Эх сурвалж: Yahoo finance


SouthGobi Resources Ltd. (TSX: SGQ, HK: 1878)

Зорилтот үнэ **1.04** Канад доллар, **BUY** үнэлгээ

Ижил төстэй компаниуд

- Таван толгой ХК
- Энержи Ресурс ХХК (MMC, Mongolian Mining Corporation)

2020 оны байдлаар Монгол Улс 31.2 сая тонн нүүрс экспортолсон. Саусгоби Ресурс Лимитед 2.63 сая тонн нүүрс (экспортын 8.4 хувь), Таван Толгой ХК 2.3 сая тонн нүүрс (экспортын 7 хувь), Энержи Ресурс ХХК 4.2 сая тонн (экспортын 13.5 хувь) нүүрс борлуулсан.



Эх сурвалж: Компаниудын санхүүгийн тайлан

Нүүрсний нөөц

ААН компани	Reserves
Саусгоби сандс ХХК (2018 он)	114 сая.тн (Овоо Толгой)
Энержи Ресурс ХХК (2021 он 1 сар)	478 сая.тн (ROM coal) 268 сая.тн (Marketable)
Таван Толгой ХК (2019 он)	185 сая.тн

Нүүрс олборлолтын хүчин чадал (Компаниудаар)

ААН, компани	Олборлолтын жилийн хүчин чадал	Ордын нэр	Нүүрс экспортолж байгаа боомт
Эрдэнэс Монгол ХХК	35,000 мян.тн	Таван толгой	Гашуун сухайт
Таван толгой ХК	2,000 мян.тн	Таван толгой	Гашуун сухайт
Энержи Ресурс ХХК	15,000 мян.тн	Таван толгой	Гашуун сухайт
Монголын Алт МАК ХХК	14,000 мян.тн	Нарийн сухайт	Шивээ хүрэн
Саусгоби сандс ХХК	9,000 мян.тн	Нарийн сухайт	Шивээ хүрэн

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

SouthGobi Resources Ltd. (TSX: SGQ, HK: 1878)

Зорилтот үнэ **1.04** Канад доллар, **BUY** үнэлгээ

Ижил төстэй Компаниудтай харьцуулсан санхүүгийн үзүүлэлт

	SGQ		MMC		TTL	
	2020	2021Q2	2020	2021Q2	2020	2021Q2
Ашгийн маржин	32%	31%	31%	26%	17%	7%
Цэвэр ашгийн маржин	-23%	17%	7%	-14%	12%	3%
Эргэлтийн харьцаа	0.2	0.6	1.4	1.1	1.9	1.7
Өр төлбөр эздийн өмчийн харьцаа	3.8	4.0	1.0	1.0	0.8	1.0
P/E харьцаа	(2.41)	3.44	5.60	21.01	11.84	195.2
EPS	(0.07)	0.02	0.03	0.01	0.21	0.01
ROE	26%	8%	3%	2%	41%	4%
ROA	-9%	3%	2%	-1%	22%	2%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	0.22	0.11	0.8	0.5	1.8	1.3

Хувьцааны ханш (ам.доллар)	0.18	0.07	0.16	0.28	2.47	2.50
Нийт хөрөнгө (мянган ам.доллар)		209,902		1,772,135		35,315
Нийт өр төлбөр (мянган ам.доллар)		280,494		906,315		17,778
Нийт эздийн өмч (мянган ам.доллар)		(70,592)		874,820		17,537
Цэвэр ашиг (мянган ам.доллар)		5,776		(13,471)		668

2021 оны хагас жилийн санхүүгийн харьцаа

Нийт ашгийн маржин

SGQ компанийн нийт ашгийн маржин хамгийн өндөр буюу 31 хувь (MMC 26%, TTL 7%), цэвэр ашгийн маржин 17 хувь (MMC -14%, TTL 3%) байна.

Эргэлтийн харьцаа

SGQ компанийн эргэлтийн харьцаа хамгийн муу буюу 0.6 (MMC 1.1, TTL 1.7) байгаа нь Компанид богино хугацааны өр төлбөрөө барагдуулахад хүндрэл учирч болзошгүй.

Хөрөнгийн өгөөж

SGQ компанийн хөрөнгийн өгөөж хамгийн өндөр буюу 3 хувь (TTL 2%, MMC -1%) байгаа нь Компани нь бусад 2 компанитай харьцуулахад хөрөнгөө зөв зохистой удирдаж буйг харуулж байна.

Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)

2021 оны эхний хагас жилийн байдлаар SGQ-н өөрийн хөрөнгийн өгөөж хамгийн өндөр буюу 8 хувь (TTL 4%, MMC 2%) байгаа нь Компани нь бусад 2 компанитай харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг зөв зохистой удирдаж байна.

Өр төлбөр эздийн өмчийн харьцаа

SGQ-н өр төлбөр эздийн өмчийн харьцаа хамгийн өндөр буюу 4 (MMC - 1, TTL - 1) байгаа нь Компани нь бусад 2 компанитай харьцуулахад өндөр өр төлбөртэйг харуулж байгаа бөгөөд хөрөнгө оруулагч, зээлдэгч нарын хувьд эрсдэл өндөр байгааг илтгэж байна.

SGQ Компанийн өр төлбөрийн байдал

■ Богино хугацаат өр төлбөр ■ Урт хугацаат өр төлбөр

66%

34%

Компанийн нийт өр төлбөрийн 64 хувийг China Investment Corporation (CIC)-н эзэмшиж буй хөрвөх эрхтэй өрийн бичиг бүрдүүлж байна. CIC нь Компанийн хувьцааны 24 хувийг эзэмшдэг.


SouthGobi Resources Ltd. (TSX: SGQ, HK: 1878)

Зорилтот үнэ **1.04** Канад доллар, **BUY** үнэлгээ

Өрсөлдөгч компаниуд

MMC


56.6% доогуур үнэлэгдсэн



Эх сурвалж: Simply wallstreet

SGQ

39% доогуур үнэлэгдсэн



Эх сурвалж: Ард Секюритиз ҮЦК-ийн үнэлгээ

Хөндлөнгийн шинжээчдийн санал (10/15/21, 16:00 EDT)

Компани	Үнэлгээ	Одоогийн ханш	Зорилтот ханш	Өсөлт/бууралтын хувь	Шинжээч
SGQ	Зарах - 1	C\$0.60	C\$0.36	-78%	Wallstreet шинжээч
MMC	Зарах - 1	\$0.35	\$0.23	-34%	Barrons

Эх сурвалж: Wallstreet Journal, Barrons

Нэгдсэн дүгнэлт

Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас 2021 оны 2 дугаар улиралд Монгол Улсын хилээр БНХАУ-руу нэвтрэх ачааны автомашины тоог хязгаарласантай холбоотой SGQ нь бараа материалын нөөцийг хянах, эргэлтийн хөрөнгийг хадгалах зорилгоор уурхайн үйл ажиллагаагаа түр хугацаанд зогсоосон. Үүний үр дүнд компанийн борлуулалтын хэмжээ буурсан байна.

Санхүүгийн үзүүлэлтийн хувьд Компани нь 2020 оны хагас жилээр 23.7 сая ам.доллар, 2020 оны жилийн эцсээр 20 сая ам.долларын алдагдалтай ажилласан бол 2021 оны хагас жилд 5.8 сая ам.долларын ашигтай ажилласан. Үүнд дэлхийн эдийн засаг дахь нүүрсний хомсдолоос үүдэлтэй нүүрсний үнийн өсөлт, Хятад Улсын эдийн засгийн нөхцөл байдал болон Компанийн бүтээгдэхүүний чанар сайжирсантай холбоотой Компанийн борлуулсан нүүрсний үнэ 2020 оны 2 дугаар улиралд 31.7 ам.доллар/тонн байсан бол 2021 оны 2 дугаар улиралд тонн тутамд 47.9 ам.доллар болж өссөн нь нөлөөлсөн байна. Цаашдаа Монгол Хятадын хилийн хязгаарлалт болон Ковид-19-н нөхцөл байдал сайжирвал Компанийн нүүрсний борлуулалтын хэмжээ, борлуулалтын орлого өсөх магадлалтай юм.

Компанийн нүүрсний нөөц нь 114 сая тонн бөгөөд Монгол Улсын нийт нүүрсний экспортын 8.4 хувийг бүрдүүлж байна. Компанийн эзэмшдэг нүүрс олборлож буй Овоо Толгой орд нь стратегийн ач холбогдол бүхий байршилтай – Хятад улстай хамгийн ойр орд юм. Мөн Компани нь нийтдээ 32,494.86 га талбай бүхий 6 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. Компани нь жилд олборлох нүүрсний хүчин чадлаараа Монгол Улсад дөрөвт орох хүчин чадалтай бөгөөд Өмнөговь аймгийн бүс нутагт тодорхой хэд хэдэн ордуудын лицензийг өмчлөн авсан байгаа нь нүүрсний салбарт өрсөлдөхүйц байр суурьтайг харуулж байна.

Компанийг бусад нүүрс олборлогч компаниудтай харьцуулан үзэхэд санхүүгийн харьцааны хувьд нийт ашгийн маржин, хөрөнгийн өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөж хамгийн сайнтай байна.

Компанийн нэгж хувьцааны үнэ 0.60 канад доллар байгаа бөгөөд бидний хорогдуулах мөнгөн урсгалын (DCF) аргаар үнэлснээр нэгж хувьцааны үнэ 1.04 канад доллар байна. Тиймээс бид **BUY** үнэлгээг санал болгож байна.

Хөрөнгө оруулалтын эрсдэл

Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцээс харахад төвлөрөл өндөртэй буюу Novel Sunrise Investment Limited болон China Investment Corporation нь нийт хувьцааны 41 хувийг эзэмшиж байна. Компанийн нийт өр төлбөрийн 64 хувийг China Investment Corporation-н эзэмшиж буй 64 хувийн хөрвөх эрхтэй өрийн бичиг бүрдүүлж байгаа нь Компани нь өрийн дарамт ихтэйг харуулж байна. Мөн Компанийн өр төлбөрөө төлөх чадварыг харуулдаг Interest coverage ratio нь 2020 онд 0.87, 2021 оны хагас жилд 1.54 гарсан нь зорилтот хэмжээ буюу 2-с бага байгаа нь Компанийн өрийн дарамтыг ихэсгэж байна.